

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Даян Дэлхийн Байгаль Хамгаалах Сангаас БОАЖЯ-ны ТХНУГ-т 2013 оноос хэрэгжүүлж буй “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ” төсөл нь Увс аймгийн “Гулзат”, Хэнтий аймгийн “Хавтгар”, Дорнод Хэнтий аймгийн “Түмэнхааншалз” зэрэг 3 орон нутгийн тусгай хамгаалалттай газар (ОНТХГ)- уудын байгаль хамгаалах менежментийн үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийн оролцоог дэмжин ажилласнаар тодорхой үр дүнд хүрээд байна. Эдгээр 3 газрын нэг нь Дорнод аймгийн Баян-Уул, Цагаан-Овоо, Хэнтий аймгийн Норовлин сумдын нутагт орших “Түмэнхаан-Шалз”-ын ОНТХГ бөгөөд тус газрын хамгаалалтын менежментэд оролцогч талуудын ээлжит хурал 2016 оны 12 сарын 22-нд Дорнод аймгийн “Хэрлэн” зочид буудлын хурлын танхимд боллоо. Тус хурлын үеэр цагаан зээрийн голомт, тархалт нутаг, түүний амьдрах орчныг ландшафтын түвшинд хамгаалахад талуудын үүрэг, оролцоог тодорхойлсон хамтын ажиллагааны санамж бичгийг хэлэлцүүлэн эцэслэж “Онон-Балж” БЦГ-ын захиргаа, “Дорнод Монгол” ДЦГ-ын захиргаа, Норовлин, Баян-Уул, Цагаан-Овоо сумдын ЗДТГазрууд гарын үсэг зурж баталгаажууллаа.



Энэхүү санамж бичиг батлагдсанаар цагаан зээрийн төллөх, идээшлэх гол байршил нутаг болох “Тосон-Хулстай” Байгалийн нөөц газар (БНГ), “Түмэнхаан-шалз” орон нутгийн тусгай хамгаалалттай газар (ОНТХГ), “Онон Балж” Байгалийн цогцолборт газар (БЦГ)-т ландшафтын түвшинд нэгдсэн хамгаалалтын менежментийг хэрэгжүүлэх боломж бүрдэж байгаа юм.